



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 4 дүгээр сар

Гадаад худалдааны эргэлт: \$2,486.5 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 2,486.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16.0%-иар буюу 472.1 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 19.8 сая ам.доллараар өссөн ч импорт 491.9 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62.2% буюу 1,546.5 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12.7% буюу 317.0 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 4.1%-иар өссөн бол ОХУ-тай хийсэн худалдаа 3.2%-иар буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$418.0 сая

Мөнгөн дүн 2015 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 511.8 сая ам.доллараар буурснаар 418.0 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 1.4%-иар өсч, импорт 32.2%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан. Гэвч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү нэмэгдсэн. 2015 он гарсаар зэсийн баяжмалын экспортын нөлөө тогтворжиж, барааны эргэлтийн өсөлт буурсан.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$454.3 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2015 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 454.3 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 465.5 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 0.13%-иар өссөн, импорт 32.5%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.675 (Туршилт тооцоо)


Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.675-д хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8.0%-иар буурч, өмнөх сараас 6.0%-иар өслөө.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд экспортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.3%-иар, импортын үнийн индекс 4.7%-иар тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтанд зэсийн баяжмал, түүхий нефтийн хилийн дундаж үнийн бууралт голлон нөлөөлсөн бол импортын үнийн бууралтанд тоног төхөөрөмж, ОХУ-аас импортлож буй нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан зэрэг нь голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2015	2014	2013	2015/2014		2014/2013	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	2,486.5	2,958.6	2,953.3	(472.1)	-16.0%	5.3	0.2%
Экспорт	1,452.3	1,432.4	1,212.5	19.8	1.4%	219.9	18.1%
Импорт	1,034.3	1,526.2	1,740.8	(491.9)	-32.2%	(214.6)	-12.3%
Тэнцэл	418.0	(93.7)	(528.3)	511.8		434.6	-82.3%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 88% + 12%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурч нийт экспортын 88%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 83%, нийт экспортын 73%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 5.6 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 5.9 нэгж хувиар тус тус буурсан байна.

Өсөлт: +1.4%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 1.4%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 0.2%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмалын экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 10%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 29%, 35%, 40%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 14%-иар бууруулжээ. Бусад бараа бүтээгдэхүүний экспорт өсөхөд машин механик тоног төхөөрөмжийн дахин экспорт болон тунгаасан зэсийн экспорт голлон нөлөөлсөн.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 216.1 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 196.3 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 19.8 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмалын тоо хэмжээ, боловсруулаагүй нефть, алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 255 сая ам.доллараар өссөн бол чулуун нүүрсний экспортын тоо хэмжээ буурсан, мөн чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 242 сая ам.доллараар буурсан байна.

Ямааны угаасан ноолуурын үнэ, тоо хэмжээ буурснаар уг бүлгийн экспорт 31.4 сая ам.доллараар буурсан. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 48.4 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2015 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар унц тутамд 1,184.4-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 8.3%-иар буурч, өмнөх сараас 0.1%-иар өссөн байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2015 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 6,364.5, 59.0 ам.долларт тус тус хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэсийн үнэ 4.9%-иар, төмрийн хүдрийн үнэ 11.3%-иар өсчээ. Харин өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал зэс 4.4%-иар, төмрийн хүдэр 44.0%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2015			2014			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Дүн	Өсөлт	% % 2
1. Ашигт малтмал	1,284	88%		1,281	89%		3	↑ 0%	0.2%
Чулуун нүүрс	4,248	194	13%	5,354	273	19%	(78)	↓ -29%	-6%
Зэсийн баяжмал	415	667	46%	317	530	37%	137	↑ 26%	11%
Төмрийн хүдэр/баяж.	1,500	81	6%	1,582	126	9%	(45)	↓ -35%	-3%
Боловсруулаагүй нефть	2,518	123	8%	2,095	207	14%	(84)	↓ -40%	-6%
Цайрын хүдэр ба баяж.	43	53	4%	27	27	2%	26	↑ 95%	2%
Мөнгөжөөгүй алт	3,362	133	9%	2,171	90	6%	43	↑ 48%	3%
Жонш, лейцит, нефелинт	81	19	1%	83	18	1%	1	↑ 4%	0%
Молибдений хүдэр/баяж	2	13	1%	1	10	1%	3	↑ 28%	0%
2. Ноос, ноолуур	35.8	2%		67.1	5%		(31.9)	↓ -47%	-2.2%
Ямааны угаа.ноолуур	656	28	2%	1,101	62	4%	(33.9)	↓ -55%	-2%
Ямааны сам.ноолуур	89	8	1%	52	5	0%	2.5	↑ 46%	4%
3. Бусад	133	9%		84	6%		48	↑ 57%	3.4%
Нийт дүн	1,452			1,432			19.8	↑ 1.4%	

% - Бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	210		(207)		3	
Чулуун нүүрс	(56)	-72%	(22)	-28%	(78)	-29%
Зэсийн баяжмал	164	120%	(27)	-20%	137	26%
Төмрийн хүдэр ба баяжмал	(6)	-15%	(38)	-85%	(45)	-35%
Боловсруулаагүй нефть	42	50%	(126)	-150%	(84)	-40%
Цайрын хүдэр ба баяжмал	16	61%	10	39%	26	95%
Мөнгөжөөгүй алт	49	14%	(6)	-14%	43	48%
Жонш, лейцит, нефелинт	(0)	-70%	1	170%	1	4%
Молибдений хүдэр ба баяжмал	2	62%	1	38%	3	28%
2. Ноос, ноолуур	(210)		(10.3)		(314)	
Ямааны угаасан ноолуур	(24.9)	-74%	(8.9)	26%	(33.9)	-55%
Ямааны самнасан ноолуур	3.9	155%	(1.4)	-55%	2.5	46%
3. Бусад	27	56%	21	44%	48.4	57%
Нийт	216.1		(196.3)		19.8	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 32% + 33% +20%

Эхний 4 сарын байдлаар нийт импортын 32%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 33%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 20%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буурсан бол хэрэглээний бүтээгдэхүүний хувийн жин 4%-иар өссөн байна.

Өсөлт: -32.2%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 14%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт нь 7%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт нь 10%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 38%-иар буюу 213 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 23%-иар буюу 100 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 42%-иар буюу 150 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 32.2%-иар буюу 492 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 23%-иар буюу 100 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 16%-иар буюу 25 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 32%-иар буюу 65 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, какао, шоколад болон согтууруулах болон согтууруулах биш ундааны импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 23%-д хүрсэн /Дүрслэл 7/. 2014 оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6 сараас эхлэн буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 37%-иар буюу 114 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 39%-иар буюу 72 сая ам.доллараар буурсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 12%-иар буюу 22 сая ам.доллараар буурсан. Уг бууралтын дийлэнх хувийг бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай орцын бүтээгдэхүүн эзэлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 42%-иар буюу 150 сая ам.доллараар буурсан. Нефтийн импорт тоо хэмжээний хувьд өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан боловч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр ийнхүү буурсан байна.

Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ 2013 оны төгсгөлөөс эхлэн тогтмол буурсан ба 2015 оны 2 сард 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн. Харин 2015 оны 3 сараас эхлэн эргэн өсч, 4 сарын байдлаар тонн тутамд 635.1 ам.долларт хүрчээ.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2015		2014		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт %	%2
Хэрэглээний бүтээгдэхүүн	327	32%	427	28%	(100)	-23%	-7%
Түргэн эдэлгээтэй	188	18%	223	15%	(35)	-16%	-8%
Хүнс	128	12%	153	10%	(25)	-16%	-6%
Эм, тариа	22	2%	24	2%	(2)	-9%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	37	4%	45	3%	(8)	-18%	-2%
Удаан эдэлгээтэй	140	14%	204	13%	(65)	-32%	-4%
Гутал, хувцас, цүнх	14	1%	20	1%	(6)	-30%	-1%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	33	3%	39	3%	(6)	-16%	0%
Авто машин, түүний салбэг хэрэгсэл	75	7%	118	8%	(43)	-36%	-3%
Бусад удаан эдэлгээтэй бараа	17	2%	27	2%	(9)	-36%	-2%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	345	33%	658	37%	(213)	-38%	-14%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	199	19%	313	20%	(114)	-37%	-20%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	32	3%	68	4%	(36)	-53%	-7%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	167	16%	245	16%	(78)	-32%	-14%
Барилгын материал	111	11%	184	12%	(72)	-32%	-13%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	35	3%	61	4%	(27)	-43%	-5%
Аж үйлдвэрлэлийн орц	155	15%	176	12%	(22)	-12%	-1%
Хүнсний орц	10	1%	13	1%	(3)	-22%	-2%
Химийн бүтээгдэхүүн	29	3%	26	2%	3	12%	2%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	4	0%	5	0%	(0)	-8%	0%
Цахилгаан эрчим хүч	42	4%	34	2%	9	25%	5%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	0	0%	(0)	-15%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	69	7%	99	6%	(30)	-30%	-17%
Нефтийн бүтээгдэхүүн	205	20%	355	23%	(150)	-42%	-10%
Дизель тунш	103	10%	185	12%	(82)	-44%	-5%
АИ-92, АИ-95	75	7%	117	8%	(42)	-36%	-3%
А-80 болон бусад	27	3%	53	3%	(26)	-49%	-2%
Бусад	2	0%	9	1%	(7)		0%
Нийт дүн	1,034		1,526		(492)	-32.2%	

% 1 - Бүтэцтэй өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

